



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН  
ТӨСӨЛД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТ**



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД  
ТАНАА

2018.10.03 № 1980  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтын дагуу  
Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн  
аудитын дүгнэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт /2 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

## Агуулга

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	2
НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ ХАНГАЖ БУЙ ЭСЭХ .....	2
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ.....	4
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ .....	5
ДӨРӨВ. УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ.....	6
ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН.....	7
ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА.....	8
ДОЛОО. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ.....	9
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:.....	9
ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ:.....	9

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөл, нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9-д “Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын . . . дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж танилцуулах” гэж заасны дагуу Үндэсний аудитын газар дүгнэлт боловсруулав.

Засгийн газраас 2019 онд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “**Цахим, ул тод, үр ашигтай**” төсвийг хэрэгжүүлэх, төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэх зорилтын хүрээнд 2019 оны төсвийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 9,676.5 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид ДНБ гэх/-ий 27.4 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 11,589.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.8 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 1,913.3 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -5.4 хувьтай тэнцэхээр төсвийн төсөлд тусгасан байна.

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хуулиудтай нийцүүлсэн бөгөөд Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлтэй хамт 5 хуульд<sup>1</sup> нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, мөн Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2 тогтоолын<sup>2</sup> төслийг тус тус бэлтгэжээ.

## НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ ХАНГАЖ БУЙ ЭСЭХ

Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, УИХ-аас баталсан 2019 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж төлөвлөсөн эсэхэд дараах дүгнэлтийг өгч байна.

<sup>1</sup> 1. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, 2. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 4. Боловсролын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 5. Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

1."Улсын Их хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай", "Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай"

Хүснэгт №1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал:

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгагдсан байдал	Хангагдсан эсэх
1	6 дугаар зүйл: 6.1.1. “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх”	2019 онд нүүрс болон зэсийн баяжмалаас төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын 3 хувиас давахаар байгаа тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцож нэг тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6,222.2 ам.доллар, нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 75.9 ам.доллар байхаар тооцсон байна.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 <sup>3</sup> -т заасны дагуу 2019 онд зэсийн баяжмал болон нүүрснээс нийт 2,615.0 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон нь нэгдсэн төсвийн орлогын 23.6 хувийг эзэлж байна. Шаардлага: Хангагдсан.
2	6 дугаар зүйл: 6.1.2. “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэсэн заалтад 19 дүгээр зүйлийн 19.6-д “6.1.2-т ... 2019 онд тухайн жилийн ДНБ-ий 6.9 хувиас илүүгүй байх” гэсэн өөрчлөлт орсон.	2019 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,913.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн нь Засгийн газраас тооцоолсон ДНБ (35,331.3 тэрбум төгрөг)-ий -5.4 хувьд хүрэхээр байна.	2019 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 5.4 хувьд хүргэн 1.5 пунктээр бууруулсан байна. Шаардлага: Хангагдсан.
3	6 дугаар зүйл: 6.1.3. “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх”	2019 оны нэгдсэн төсвийн төслийн нийт зарлагын өсөлт 20.1 хувь байхаар тооцжээ.	2007-2018 оны дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 20.5 хувь байна. Шаардлага: Хангагдсан.
4	6 дугаар зүйл: 6.1.4. “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх” гэсэн заалтад 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т ... 2019 онд	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг 2019 оны эцэст 19,551.6 тэрбум төгрөг байхаар төсвийн төсөлд тусгасан нь тооцоолсон ДНБ-ий 55.3 хувьтай тэнцэхээр байна.	2019 оны нэгдсэн төсвийн төсөлд Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийг 23,322.4 тэрбум төгрөг байхаар тооцоолж, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлснээр 19,551.6 тэрбум төгрөг буюу тооцоолсон ДНБ-ий 55.3 хувьд хүрэх төлөвтэй байна.

<sup>3</sup> 4.1.2. “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг;

ДНБ-ий 75 хувиас хэтрэхгүй байна” гэсэн өөрчлөлт орсон.

Шаардлага: Хангагдсан.

Эх сурвалж: \*Төсвийн хүрээний мэдэгдэл, ЗГ-с өргөн мэдүүлсэн хуулийн төсөл

**Дүгнэлт:** 2019 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан тусгай шаардлагуудыг хангаж байна.

Хүснэгт №2. Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлсэн байдал:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл /2018.05.25-нд батлагдсан/	2019 оны Төсвийн төсөл	Өөрчлөлт
1. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	8.0	-
2. Хэрэглээний үнийн индексийн түвшин	8.0	8.0	-
3. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум.төгрөг/	8,888.0	9,676.5	788.5
- ДНБ-д эзлэх хувь	<b>25.6</b>	<b>27.4</b>	<b>1.8</b>
4. Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум.төгрөг/	10,993.8	11,589.8	596.0
- ДНБ-д эзлэх хувь	<b>31.7</b>	<b>32.8</b>	<b>1.1</b>
5. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт /тэрбум.төгрөг/	1,342.3	1,938.2	595.9
- ДНБ-д эзлэх хувь	<b>3.9</b>	<b>5.5</b>	<b>1.6</b>
6. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум.төгрөг/	(2,105.8)	(1,913.3)	192.5
- ДНБ-д эзлэх хувь	<b>(6.1)</b>	<b>(5.4)</b>	<b>0.7</b>
7. Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум.төгрөг/	2,890.1	3,214.8	324.7
- ДНБ-д эзлэх хувь	<b>8.3</b>	<b>9.1</b>	<b>0.8</b>
8. Улсын өрийн нийт хэмжээ, ӨҮЦ-ээр /тэрбум.төгрөг/	19,210.2	19,551.6	341.4
- ДНБ-д эзлэх хувь	<b>55.3</b>	<b>55.3</b>	<b>0.0</b>
9. Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум.төгрөг/	677.9	694.5	16.6
- ДНБ-д эзлэх хувь	<b>2.0</b>	<b>2.0</b>	-

Эх сурвалж: ЗГ-с өргөн мэдүүлсэн хуулийн төсөл 2018.05.25-нд батлагдсан 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөлөл

**Дүгнэлт:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар төсвийн тогтвортой байдлыг хангах үндсэн 9 шалгуур үзүүлэлт баталснаас 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд 5 нь хангагдаагүй байгаа боловч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 192.5 тэрбум төгрөгөөр бууруулж -1,913.3 тэрбум төгрөг байхаар тооцож, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг ДНБ-д эзлэх хувийг 1.5 пунктээр бууруулж -5.4 хувь болгон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцүүлсэн байна.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 11,067.0 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн нийт орлогыг 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан Нэгдсэн төсвийн

тэнцвэржүүлсэн орлогын хэмжээнээс 788.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 9,676.5 тэрбум төгрөг байхаар тооцсон байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу 2019 оны нэгдсэн төсвийн орлогын гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүн зэс, нүүрс байхаар тооцжээ.

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,676.5 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 88.7 хувийг татварын орлогоор, 11.3 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр тооцжээ. Үүнээс татварын орлогыг 2018 оны батлагдсан төсвөөс 2,316.8 тэрбум төгрөгөөр буюу 37.0 хувиар, татварын бус орлогыг 128.3 тэрбум төгрөгөөр буюу 13.3 хувиар өсгөхөөр тооцсон байна.

#### **Дүгнэлт:**

- Татварын орлогыг 2019 оны төсвийн төсөлд 2,316.8 тэрбум төгрөг буюу 37.0 хувиар өсөхөөр тооцоолсон нь сүүлийн 9 жилийн дундаж өсөлтөөс 5.2 дахин их бөгөөд уул уурхайн салбараас орох орлогыг бүрэн дайчилсан гэж үзээд орлого нэмэгдүүлэх саналгүй байна.
- Дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд саарах чиг хандлага болон экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэс, цайр, газрын тосны үнэ буурах төлөвтэй байгаа, нүүрсний борлуулалтын тоо хэмжээг өмнөх оны төлөвлөгөөнөөс 9.8 сая тонн буюу 30.4 хувиар нэмэгдүүлэн өөдрөгөөр тооцсоноос төсвийн орлогын төлөвлөгөө биелэхгүй байх, төсвийн нийт дүнд эрсдэл бий болох магадлалтай байна.

#### **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ**

Нэгдсэн төсвийн 2019 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 11,589.8 тэрбум төгрөгөөр төлөвлөснийг 2018 оны төсөвтэй харьцуулбал 1,938.2 тэрбум төгрөгөөр буюу 20.0 хувиар нэмэгдүүлж тооцжээ.

Зарлагын өсөлтийн бүтцийг авч үзвэл, урсгал зарлагыг 774.9 тэрбум, хөрөнгийн зардлыг 1,286.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 123.0 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн байна.

Урсгал зардлын хэмжээг нэмэгдүүлж байгаа томоохон арга хэмжээг дурдвал, цалин тэтгэврийг нэмэгдүүлэхэд 720.0 тэрбум, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд 146.2 тэрбум, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд 89.3 тэрбум төгрөг тус тус нэмэгдэж, зээлийн үйлчилгээний төлбөр 285.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

#### **Дүгнэлт:**

- Нэгдсэн төсвийн тэнцлийг сайжруулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн тэвчиж болох, 2018 оны гүйцэтгэлийн түвшинд барих зардлуудыг ач холбогдлоор эрэмбэлж ангилан, 2019 оны төсвийн төсөл боловсруулахад баримталсан зарчимтай нийцүүлэх нь зүйтэй байна.

- Төсвийн төлөвлөлт, төрийн албан хаагчийн орон тоо, цалингийн сангийн мэдээлэл бүхий нэгдсэн цахим системийг бий болгож, зардал хэмнэх нөхцөл бололцоог судалж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## ДӨРӨВ. УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ

Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 21 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2,546.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 876 төсөл, арга хэмжээг 1.217.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Нийт арга хэмжээний 361 буюу 41.2 хувийг шилжих, 515 буюу 58.8 хувийг шинээр эхлүүлэх арга хэмжээ эзэлж байна.

Хүснэгт №3. Улсын төсвөөс 2019 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, ангиллаар

*(тоо, тэрбум төгрөг)*

Хөрөнгө оруулалтын ангиллаар	Шинэ			Шилжих		
	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих
Барилга байгууламж	395	1,106.8	576.3	329	1,182.9	433.8
Их засвар	75	84.9	79.0	27	52.1	25.1
Тоног, төхөөрөмж	42	102.5	93.5	4	11.9	4.7
ТЭЗҮ	3	3.5	3.5	1	2.2	1.7
<b>НИЙТ ДҮН</b>	<b>515</b>	<b>1,297.7</b>	<b>752.3</b>	<b>361</b>	<b>1,249.1</b>	<b>465.3</b>
Эзлэх хувь	58.8	51.0	61.8	41.2	49.0	38.2

*Эх сурвалж: Сангийн яам*

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 131 төсөл арга хэмжээг баталгаажсан зураг, төсөвгүйгээр хэрэгжүүлэхээр төсөвлөснөөс 2018 оны эхний 8 сарын байдлаар хэрэгжилт нь 30.8 хувьтай байна.

Монгол Улсын 2019 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 515 төсөл, арга хэмжээнээс 71.3 хувь нь Төсвийн тухай хуулийн 29.4-т заасан техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь магадлалаар баталгаажгаагүй, мөн 2018 оны 10 дугаар сарын байдлаар гэрээ байгуулагдаж, ажил эхлээгүй хөрөнгө оруулалтын шилжих нийт 54 төсөлд 75.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн зэргээс харахад 2019 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хугацаа алдах эрсдэлтэй байна.

Түүнчлэн 2019 оны төсвийн төсөлд гэрэлтүүлэг, зам, талбайн тохижилт, мал угаах онгоц, ногооны зоорь зэрэг нийслэл, орон нутгийн төсөв, урсгал зардлаар санхүүжүүлэх боломжтой нийт 32 төсөлд 21.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөжээ.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төсөлд төрийн өмчийн концессын жагсаалтад тусгагдсан “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа



концессын гэрээнүүдээс барилга угсралтын ажил дуусаж ашиглалтад орсон болон 2019 онд ашиглалтад орох нийт 464.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төслийн эргэн төлөлтөд 144.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тусгасан байна.

УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 13 дахь заалтын дагуу “Барих-шилжүүлэх” нөхцөлөөр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг УИХ тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар батлах болсонтой холбогдуулан Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдах хүртэл дээрх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байх”-аар шийдвэрлэсний дагуу “барих-шилжүүлэх” төрлөөр нэмж концессын гэрээ байгуулаагүй нь төсөвт нэмэлт өрийн дарамт учруулахаас сэргийлсэн арга хэмжээ болсон байна.

#### **Дүгнэлт:**

- Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтын ихэнх төсөл, хөтөлбөрүүд нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасны дагуу нийгэм, эдийн засгийн ач холбогдлоороо эрэмбэлэгдээгүй, улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, салбарын хөгжлийн бодлоготой уялдаагүйгээс 2018 оны Төсвийн хүрээний мэдэгдлээс давсан, төсвийн хязгаарыг баримтлаагүй, шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөх хуулийн шаардлага хангаагүй байгаа нь цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж, төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэх шаардлагатайг харуулж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус төсөл арга хэмжээг төлөвлөх, түүний эх үүсвэрийг давхардуулах эрсдэл байгаа тул хөрөнгө оруулалтын нэгдсэн программ хангамжтай яаралтай нэвтрүүлэх шаардлагатай байна.

#### **ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН**

Орон нутгийн төсвийн суурь орлогыг 2019 онд 1,123.3 тэрбум, суурь зарлагыг 900.1 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ.

Төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор аймгуудад Улсын төсвөөс хөрөнгө оруулалтын эх үүсвэрт 2018 оноос 59.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2019 онд 189.0 тэрбум төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн байна.

Улсын төсвөөс аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн дүнг 2018 оноос 62 хувиар нэмэгдүүлж, 144.0 тэрбум төгрөгт хүргэж төлөвлөсөн байна.

**Дүгнэлт:** Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөрөнгийн үр өгөөжийг тооцож, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.

## ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд Засгийн газрын өрийн нийт хэмжээг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлснээр 19,551.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 55.3 хувьтай тэнцэхээр төлөвлөсөн нь гадаад валютын ханшийн тооцооллоос шалтгаалан батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлээс 341.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т “өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг ... 2019 оны төсвийн жилд 75 хувиас хэтрэхгүй байх” гэж заасантай нийцэж байна.

Мөн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичигт тусгасан “2016-2020 онд хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгож, тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 58.6 хувиас хэтрүүлэхгүй байх” өрийн зохистой түвшний шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Гэвч төсвийн төслийн баримт бичигт дурдсанаар манай улс хуваарийн дагуу 2021 онд 500.0 сая ам.долларын Мазаалай, 2020 онд 1.0 тэрбум ам.долларын Чингис, 2023 онд 600.0 сая ам.долларын Хуралдай, 2024 онд 800.0 сая ам.долларын Гэрэгэ бондын төлбөрийг тус тус төлөхөөр байгаа нь дунд хугацаанд өрийн дарамт хэвээр хадгалагдахаар байна.

### **Дүгнэлт:**

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ДНБ-д эзлэх өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн хувь хэмжээ хуулиар зохицуулагдсан тусгай шаардлагын түвшинд байна.
- Засгийн газрын өрийн бүтэц дэх гадаад үнэт цаасны эргэн төлөлтийн хуваариар дунд хугацаанд өрийн дарамт өндөр хэмжээнд хадгалагдахаар байгаа тул төсвийн төслийн баримт бичигт дурдсан өрийн тогтвортой байдлыг хангах, шинээр өр үүсгэхгүй байх, эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр хугацаанаас нь өмнө төлж барагдуулах боломжийг хангах шаардлагатай байна.
- Цаашид төрөөс жил бүрийн мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлтэй уялдуулан үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлага хэвээр байна.

## ДОЛОО. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,913.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснийг 2018 онд батлагдсан дүнтэй харьцуулахад 647.2 тэрбум төгрөгөөр бууруулжээ.

Нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 2019 онд Засгийн газрын дотоод үнэт цаас гаргалтаас 252.2 тэрбум, гадаад төслийн болон хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрээс 823.7 тэрбум, Ирээдүйн өв сан /Хүний хөгжил сан/-гийн авлагын барагдуулалтаас 465.4 тэрбум, Ирээдүйн өв сангаас 50.0 тэрбум, Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс 322.0 тэрбум, нийт 1,913.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

### ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөл нь төсвийн хүрээний мэдэгдлээс төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг бууруулж, төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна.
- Макро эдийн засгийн төсөөлөл, гадаад, дотоод хүчин зүйлсийг үндэслэлтэй тооцоолохгүйгээр дунд хугацаанд баримтлах Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж, баталж байгаагаас уг баримт бичгийг богино хугацаанд өөрчилж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн ач холбогдлыг бууруулж байна.
- Үндэсний аудитын газраас нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Улсын Их Хурлын анхааралд толилуулсан Төсвийн тогтвортой байдал хангагдахгүй байгаа талаарх удаа дараа давтагдаж буй зөрчлийг Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийг батлахдаа бүрэн залруулж, зөвлөмжийг цаашид жил бүрийн төсөвт баримталж, мөрдөж хэвших шаардлагатай байна.

### ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ:

- Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг эдийн засгийн зардлын зүйл ангитай уялдуулан хүрэх үр дүн бодлого чиглэлийг баримталсан төсвийн төслийг боловсруулж байх.
- Улсын болон орон нутгийн төсвийн хоорондын харилцааг боловсронгуй болгох.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрх хэмжээ зэрэг асуудлыг нарийвчлан судалж, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх, үр дүнгийн гэрээнд тусгаж байх;
- Төсвийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангахад анхаарч, бүх шатны төсвийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэхэд хууль, тогтоомж, дүрэм, журмын шаардлагыг мөрдөх, хариуцлага тооцох механизмыг сайжруулах, үр дүнг тооцох;

- Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгахгүй байх, зөрчсөн албан тушаалтанд тооцох хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэн төсөвт тусгаж хэрэгжүүлэх, үр ашгийг тооцох, хяналтын тогтолцоог сайжруулж, нэгдсэн програм хангамжтай болж, улс орон нутгийн түвшинд бодлого, төлөвлөлтийг нэгтгэх,
- Орон нутгийн шинж чанартай хөрөнгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй байх.



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/174

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд өгөх саналын төслийг боловсруулах ажлын удирдамж, төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, ажил гүйцэтгэх хуваарийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд санал өгөх ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, санал дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 оны 10 дугаар сарын 12-ны дотор танилцуулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасан цаглабарт хугацаанд УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Оюунбилэг)-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовын  
2018 оны 09 сарын 12 өдрийн 174 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ  
САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: С.Оюунбилэг (Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор)

Гишүүд: Ц.Наранчимэг (Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор)

Д.Энхболд (Стратегийн удирдлагын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор)

Л.Одгэрэл (Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторовын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Энхбаатар (Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор)

Н.Анхбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Г.Гүнжидмаа (САГ-ын аудитын менежер)

С.Оюунгэрэл (САГ-ын аудитын менежер)

Я.Самбууням (САГ-ын аудитын менежер)

Л.Эрдэнэчулуун (ГАГ-ын аудитын менежер)

Б.Саруул (ГАГ-ын аудитын менежер)

Нарийн бичгийн дарга: Л.Хонгорзул (САГ-ын ахлах аудитор)

## Тэмдэглэл